23 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдол гаргах

23.1.Энэ хуулийн 14 дүгээр зүйлээс бусад зүйл, заалтыг зөрчсөн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах үндэслэл болно.

23.2.Энэ хуулиар баталгаажуулсан жендэрийн эрх тэгш байдлыг хангах, мөн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан зөрчсөн гэж үзвэл үйлдвэрчний эвлэлийн болон бусад олон нийтийн байгууллага гомдол гаргах эрхтэй.

23.3.Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан ажлын байрандаа жендэрийн ялгаварлан гадуурхалт гаргасан бол ажил олгогчийг нэгэн адил энэ хуулийг зөрчсөнд тооцно.

24 дүгээр зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн талаархи гомдлыг хянан шийдвэрлэх

24.1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендэрийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, эдгээр хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлнэ.

24.2.Жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн талаархи гомдлын үндэслэл хөдөлмөрийн гэрээ буюу хамтын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэх боломжтой нь тогтоогдвол гэрээний талууд гомдлыг хөдөлмөрийн эрхийн болон хөдөлмөрийн сонирхлын маргааныг зохицуулах журмаар шийдвэрлэнэ.

/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

24.3.Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гарсан маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.

24.4.Бэлгийн дарамтын талаархи гомдлыг хянан шийдвэрлэх явцад илэрсэн хувь хүнтэй холбоотой мэдээллийг хувийн нууц гэж үзэж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаална.

/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

ТАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

25 дугаар зүйл.Гэм хор учирснаас үүсэх хариуцлага

25.1.Ажилтан хөдөлмөрийн гэрээ болон албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад энэ хуулийг зөрчиж бусдад гэм хор учруулсан бол Иргэний хуулийн 498.1, 498.2-т заасны дагуу түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хариуцан арилгана.

25.2.Ажил олгогч энэ хуулийн 11.4-т заасан арга хэмжээ авсан болохоо нотолбол энэ хуулийн 25.1 дэх хэсэг хамаарахгүй.

26 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ хэсгийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

26.2.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гаргаж өгөөгүй зэргээр Комиссын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ хэсэгт 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

26.3.Гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

27 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

27.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тусын эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

27.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, түүнчлэн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааны хэрэгжилтэд үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллага, иргэд олон нийтийн хяналт тавина.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



ЖЕНДЭРИЙН
ҮНДЭСНИЙ ХОРОО

**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ
ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2022-2031)**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Салбар дундын стратеги төлөвлөгөө
батлах тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.3.1, Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 2.3, 2.9-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-г хавсралт ёсоор баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэн, хэрэгжүүлж ажиллахыг жендэрийн салбар хороо, салбар зөвлөлийн дарга нар болон хорооны гишүүдэд тус тус даалгасугай.

3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэсний хэмжээнд нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо, санал санаачилгыг дэмжин хамтарч ажиллах, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны хяналт-шинжилгээг тогтмол, үнэлгээг 2 жил тутам хийж, биелэлтийн мэдээллийг жил бүр танилцуулахыг Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Т.Энхбаяр/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Жендэрийн үндэсний хорооны 2022 оны
... дугаар төлөвлөлийн хэвсрэлт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ /2022-2031 ОН/

№	Зорилго, зорилт, үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Сурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжүүлэх байгууллага	
				2021/2022	2026	2031	2026	Үндсэн	Хамтрагч
1.	Зорилго 1. Охид, хөвгүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ.	2	3	4	5	6	7	8	ЖУХ, Бүх яам
1.1	Зорилт 1.1. Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгана.	Жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлт. Боловсролын түвшин	Оноо	0.994	0.996	0.998	БШУЯ	ЭМЯ	ЖУХ, БТСУХ, Бүх аймаг дүүргийн Засаг дарга
1.1.1	Эрүүл мэндийн салбарын жендэрийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын мэдлэг, хандлага, дадлыг жендэрийн мэдрэмжтэй хэвшүүлэх чадавч бүрдүүлнэ.	Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү	Жил	9.5	8	7	ЭМЯ	ЭМЯ	ЖУХ
1.1.2	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зардал, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтад жендэрийн шинжилгээ хийж, шийдвэр гаргалтад ашиглана.	Сургалтад хамрагдсан ажилтан, хүйсээр Эрүүл мэндийн нийт төсөвт нийгмийн эрүүл мэндэд зарцуулсан төсөв	Хувь	0	70	100	ЭМЯ	ЭМЯ	ЖУХ
1.1.3	Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, дэд бүтцийг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлнэ.	Жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээ, дэд бүтэц бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллага	Хувь	0	20	40	ЭМЯ	ЭМЯ	ЖУХ

1.1.4	Жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх (эрүүл хоол хүнс хэрэглэх, хорт зуршлаас сэргийлэх) замаар зоонозын халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээг бодлогын баримт бичигт тусгаж хэрэгжүүлнэ.	Бодлого батлагдсан эсэх, бодлогын хэрэгжилт	Тийм/үгүй Хувь	Үгүй 0	Тийм 50	- 100	ЭМЯ	ХХААХУЯ, БШУЯ
1.1.5	Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүгэй байдал, түүний шалтгааныг газарзүйн байршлаар нарийвчлан судалж, орон нутгийн төлөвлөлтөд тусгана.	Судалгаа, Төлөвлөлтөд тусгасан аймаг, дүүрэг	Тоо	0	15	30	ЭМЯ	Аймаг, дүүргийн ИТХ, Засаг дарга
1.1.6	"Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалтыг сайжруулна.	Арга хэмжээ	Тоо	50	100	-	ЖҮХ	Бүх яам, аймаг дүүргийн Засаг дарга, ИТХ
1.1.7	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинет, стандартын дагуу аймаг, дүүрэг бүрт байгуулж, хүний нөөцийг бэлтгэж, тоног төхөөрөмжөөр хангана.	Стандарт хангасан кабинет, хүний нөөцтэй аймаг, дүүрэг	Тоо	14	30	-	ЭМЯ	Аймаг, дүүргийн ИТХ, Засаг дарга
1.1.8	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетаар үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх нөлөөллийн стратеги хэрэгжүүлж байгаа Орхон зэрэг аймгийн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	Сайн туршлагыг нэвтрүүлсэн орон нутаг	Тоо	1	10	21	ЭМЯ	Бүх шатны Засаг дарга
1.1.9	Эрэгтэйчүүдийн хөгжлийн төвийг байгуулан туршиж, хөгжүүлнэ.	Байгуулсан төв	Тоо	0	1	5	ХНХЯ	ЖҮХ, Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.1.10	Эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн манлайлагч, олны танил эрэгтэйчүүдийн ололт амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэнэ.	Хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүн	Тоо	0	10	15	Соёлын яам	ЦХХХЯ, СНЭ

1.1.1.11	Согтууруулах, мансууруулах бодис, тамхи зэрэг хорт бодисын хэрэглээг хязгаарлахад иргэдийн оролцооны болон эрх зүйн бусад механизмыг боловсронгуй болгоно.	Хууль тогтоомжийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	ЭМЯ, ХНХЯ, Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.1.1.12	Эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржихуй, жирэмсний болон дараах үеийн эрүүл мэндийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлнэ.	Судалгаа, бодлого төлөвлөлтийн хэрэгжилт	Хувь	40	70	100	ЭМЯ	ЖУХ
1.1.1.13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, тэднийг асран харгалзагчдын нийгмийн амьдралд оролцоход тулгарч байгаа саад бэрхшээлд жендэрийн шинжилгээ хийж, салбар дундын төлөвлөлт хийж хэрэгжүүлнэ.	Жендэрийн шинжилгээ, бодлого төлөвлөлт хийгдсэн эсэх, хэрэгжилт	Тийм/үгүй Хувь	Үгүй	Тийм	- 50	ХНХЯ	ЖУХ, ЭМЯ, Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.2	Зорилт 1.2. Эрүүл идэвхтэй, жендэрийн ялгаварлалгүй амьдралын хэв маягийг боловсрол, соёл, спортоор төлөвшүүлнэ.	Эрүүл идэвхтэй, жендэрийн ялгаварлалгүй амьдрах дадал төлөвшүүлэх богино хугацааны хувилбарт тогтмол сургалт	Тоо	Бэлэн бус	Боловсролын түвшин бүрд 30	Боловсролын түвшин бүрд 100	БШУЯ	ЖУХ
1.2.1	Хүн бүрийг эрүүл, идэвхтэй жендэрийн ялгаварлалгүй амьдралын хэв маягт сургах боловсрол, соёлын агуулгыг тодорхойлж, хууль тогтоомжид тусгаж хэрэгжүүлнэ.	Боловсрол, соёлын хууль тогтоомжид өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.	Тийм	Тийм	БШУЯ	Соёлын яам
1.2.2	Бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх хөдөлгөөн өрнүүлэхэд эрэгтэйчүүдийн байгууллагын оролцоог дэмжинэ.	Оролцоог дэмжсэн арга хэмжээ	Тоо	0	5	10	БТСУХ	ЭМЯ, ЖУХ, Эрэгтэйчүүдийн ТББ

1.2.3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэгийн болон бага ангийн багш)-ын мэргэжлээр суралцах эрэгтэй, шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн чиглэлээр суралцах эмэгтэй элсэгчдийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Тусгай арга хэмжээ авсан эсэх, Цэцэрлэгийн болон бага ангийн багш мэргэжлийн чиглэлээр эрэгтэй элсэгчдийн эзлэх хувийн өсөлт, STEM (Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик)-ийн чиглэлээр суралцах эмэгтэй элсэгчдийн эзлэх хувийн өсөлт, Мэдээллийн технологи чиглэлээр эмэгтэй элсэгчдийн эзлэх хувийн өсөлт	Тийм/үгүй Хувь	- 3.9	Тийм Эрэгтэй элсэгчдийн эзлэх хувь өссөн байна. Эмэгтэй элсэгчдийн эзлэх хувь өссөн байна.	Тийм Салбарт ажиллагчдын хүйсийн тэнцвэрт байдал хуульд заасан квотыг хангасан байна.	БШУЯ	ЖУХ
1.2.4	Бүх шатны боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт жендөр болон гэр бүлийн боловсролын агуулгыг суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулж тусгана.	Боловсролын багц хуульд холбогдох өөрчлөлт хийгдсэн эсэх Жендэрийн хэвшмэл ойлголтоос татгалзахад туслах ном зохиолын жагсаалтыг ерөнхий боловсролын заавал эзэмшүүлэх сургалтын агуулгад тусгаж баталсан эсэх	Тийм/үгүй Тийм/үгүй	Үгүй Үгүй	Тийм Тийм	Тийм Тийм	БШУЯ БШУЯ	ХНХЯ, ГБХЗХГ

1.2.5	Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөгшүүлэх "Дархан бэр" зэрэг арга хэмжээг хориглох, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зүйн соёл, хэвшил төлөвшүүлэх сургалт сурталчилгааг "иргэдийн эрх зүйн нийгэмшил" хандлагын хүрээнд нэвтрүүлнэ.	Сургалт сурталчилгааны бүтээгдэхүүн	Тоо	2	8	18	ХЗДХЯ	Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.2.6	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын арга зүйг хөгжүүлж, сум, хороонд жигд хүртээмжтэй зохион байгуулна.	Сургалт хийгдэж буй сум, хороо	Хувь	0	70	100	ХЗДХЯ	ХНХЯ
1.2.7	Дотуур байранд амьдардаг бага ангийн хүүхдийг дэмжих туслах багш ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлж, дотуур байранд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх орчин, үйлчилгээг бий болгоно.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх, Орчин, үйлчилгээ бүрдсэн дотуур байр	Тийм/ Үгүй Хувь	Боловс-ролын багц хуулийн төсөл	Тийм 30	- 100	БШУЯ	Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.2.8	Малчдын хүүхдэд СӨБ, бага боловсрол олгох орчныг жендэрийн хувьд ээлтэй болгох Увс аймгийн Бөхмөрөн сумын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	Сайн туршлага нэвтрүүлсэн сум	Хувь	Туршлага дэлгэрүүлэх төлөвлөгөө	10	20	БШУЯ	Аймаг, сумын Засаг дарга, ИТХ
1.2.9	Боловсролын үйлчилгээг жендэрийн агуулга, мэдрэмжтэй хүргэх, мэргэжил сонголт дахь жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөөг арилгах чадавхыг ерөнхий боловсролын сургуулийн багш нарт системтэй олгоно.	Сургалтын тогтолцоо бүрдсэн эсэх, чадавхжсан багш	Тийм/ үгүй Хувь	Үгүй -	Тийм -	Тийм	БШУЯ	ЖУХ
1.2.10	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг хорт зуршил, болзошгүй эрсдэлт зан үйл болон жендэрийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх үйл ажиллагааг эцэг эх, багш, сурагчид (охид, хөвгүүд)-ын клуб, бүлгээр дамжуулан идэвхжүүлж дэмжинэ.	Оролцоог идэвхжүүлсэн сургууль	Тийм/ үгүй, Хувь	Мэдээлэл бэлэн бус	Тийм 30	- 70	БШУЯ	ХНХЯ Бүх шатны Засаг дарга, ИТХ

1.2.11	Цэцэрлэгийн болон бага ангийн багшийн үндсэн цалин хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Тусгай арга хэмжээ авсан, хэрэгжилтэд үнэлгээ хийсэн эсэх	Тийм/ үгүй	Үгүй	Тийм	Тийм	БШУЯ	ТАЗ, ХНХЯ
1.2.12	Сургууль завсардсан охид, хөвгүүд, ерх толгойлсон залуу эмэгтэйчүүдийг дахин суралцуулах, мэргэжил олгоход шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.	Суралцагчид нас, хүйсээр	Тоо	Тодорхойлох шаардлагатай	Суурийг 35 хувиар нэмэгдүүлэх	Суурийг 70 хувиар нэмэгдүүлэх	БШУЯ	ХНХЯ
1.2.13	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад ажиллаж буй сэтгэл зүйчийг жендерийн чиглэлээр мэргэшүүлнэ.	Жендерийн чиглэлээр мэргэшсэн сэтгэл зүйчтэй сургалтын байгууллага, байгууллагын төрлөөр	Хувь	0	50	100	БШУЯ	Бүх шатны Засаг дарга
1.2.14	Орон нутгийн МСУТ, политехник коллежийн "Малчин" мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөрт жендерийн үнэлгээ хийж, жендерийн үзэл баримтлал нэвтрүүлж боловсронгуй болгоно.	Жендерийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөртэй эсэх	Тийм/ үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХХААХҮЯ	БШУЯ
1.2.15	Залуучуудын хөгжлийн төвийн сургагч багшид зориулсан жендерийн сургалтын гарын авлага боловруулж, сургалтын тогтолцоонд нэвтрүүлнэ.	Гарын авлагаар бэлтгэгдсэн сургагч багш	Тоо	0	26	32	ХНХЯ	Залуучуудын хөгжлийн төв
1.2.16	Олон нийтийн мэдээлэл, зар сурталчилгааны агуулгад хэвлэл мэдээллийн жендерийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлнэ.	Шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлсэн байгууллага, Сайн туршлага	Хувь Тоо	0 0	30 3	60 5	ЦХХХЯ	ХХЗХ, Соёлын яам, Мэргэжлийн холбоод

1.2.17	Хэвлэл мэдээлэл, урлагийн бүтээлийн агуулга, тэдгээртэй холбогдон нийгмийн сүлжээгээр тархах мэдээлэлд жендэрийн өнцгөөс хяналт тавих олон нийтийн механизм бий болгоно.	Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт хийгдсэн эсэх Олон нийтийн хяналтын механизмдын хэлбэр (Жендэрийн шинжээчдийн бүлэг гэх мэт.)	Тийм/үгүй Тоо	Үгүй 1	Тийм 3	Тийм 5	Шадар сайд, ЖУХ ЖУХ	ЦХХХЯ, МҮОНРТ, Мэргэжлийн холбоод, ТББ Мэргэжлийн холбоод, ТББ, МНУХ
1.2.18	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар нийтийн эрх ашгийн өмгөөлөл явуулах, шаардагдах зардлын санхүүжилтийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт бий болгоно.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ЖУХ	ХЭҮК, ХЗДХЯ, ТББ, Хуульчдын холбоо
1.3	Зорилт 1.3. Гэр бүл дэх тэгш харилцаа, хамтын үүрэг хариуцлагыг дэмжинэ.	Гэр бүлийн хөгжлийн индекс /гэр бүлийн боловсрол эзэмшилт, хамтын амьдралын жил, гэр бүлийн орлого/	Индекс	-	Шинээр тооцох	-	ХНХЯ	ГБХЗХГ
1.3.1	Өрх, гэр бүлийн бүтэц, гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлтийг үндэслэн гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг сайжруулж, Гэр бүлийн тухай хуульд хамтран амьдрах хэлбэр, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгана.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	ХНХЯ
1.3.2	Гэрлэлтийн гэрээний ач холбогдлыг сурталчлан таниулж, дэмжинэ.	Арга хэмжээ	Тоо	0	5	10	ХЗДХЯ	ХНХЯ
1.3.3	Эцэг эхийн үүрэг хариуцлага, ажил-гэр бүлийн үүргээ хослуулах, гэр бүлийн боловсрол, харилцааны талаарх мэдлэг, ойлголт олгох үйлчилгээг сум хорооны түвшинд бий болгоно.	Үйлчилгээг нэвтрүүлсэн сум, хороод	Хувь	0	30	70	ХНХЯ	Бүх шатны ИТХ, Засаг дарга

1.3.4	Хүүхэд асрах чөлөөг эцэг, эх хуваалцах талаарх хуулийн заалтыг сурталчлан таниулна.	Арга хэмжээнд хамрагдсан ажиллагчид	Хувь	0	60	100	ХНХЯ	ҮЭ, АОМХ, Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.3.5	Хүүхдээсээ тусдаа амьдарч байгаа эцэг, эх хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх үүргээ тэгш биелүүлэх гэрээ байгуулан хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	ХНХЯ
1.3.6	Хүүхдийн тэтгэмж тогтоосон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх явцад хариуцагч /эцэг, эх/ тодорхой эрхэлсэн ажилгүй, орлогын эх үүсвэргүй болох нь тогтоогдсон бол холбогдох сангаас гаргуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар эргүүлэн төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	ХНХЯ
1.3.7	Хот хөдөөгийн залуу гэр бүлд амины орон сууц барих, бизнес эрхлэхэд зориулан хүүгүй зээл олгох, мөргөжил арга зүйн дэмжлэг үзүүлэх инкубатор ажиллуулна.	Инкубатортой аймаг, дүүрэг, хүүгүй зээл авсан залуу гэр бүл	Тоо	0	15	30	ХНХЯ	Сангийн яам, Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга, Монгол банк
1.3.8	Эерэг, зөв эр хүн, хариуцлагатай аав байх талаар өсвөр үе, олон нийт, эрэгтэйчүүдэд чиглэсэн олон ангит кино, драм, видео контент, шторк зэрэг бүтээгдэхүүн гаргана.	Бүтээгдэхүүн, төрлөөр	Тоо	5	10	20	Соёлын яам	ХНХЯ, ГБХЭХГ
1.4	Зорилт 1.4. Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн амьдралын орчин, суурь нөхцөлийг сайжруулна.	Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийн хэрэгжилт: Хөдөө ажиглаж, амьдарч буй иргэд	Хувь	30.5	40	60	ЭЗХЯ	Бүх яам

1.4.1	Аймгийн төвөөс алслагдмал амьдарч буй жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын явуулын тусламж, үйлчилгээг хөгжүүлж, эхийн амрах байртай болгож, сумандаа амаржих нөхцөлийг бүрдүүлнэ.	Эхийн амрах байртай болгож, сумандаа амаржих нөхцөлийг бүрдүүлсэн сум	Хувь	0	30	70	ЭМЯ	Аймаг, сумын ИТХ, Засаг дарга
1.4.2	Малчин эмэгтэй, эрэгтэйчүүдэд бэлгийн, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, хүчирхийлэлгүй харилцааны талаарх мэдээллийг тогтмол хүргэнэ.	Мэдээллийг тогтмол хүргэдэг сум, баг	Хувь	0	50	100	ЭМЯ	Аймаг, сум, багийн Засаг дарга, ИТХ, ХНХЯ
1.4.3	Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх арга технологи нэвтрүүлэх, хос аж ахуй эрхлэх, хоршоо болон сүлжээнд нэгдэн ажиллах чиглэлээр малчин өрхийн эмэгтэйчүүдэд сургалт, зөвлөгөө өгөх инкубатор хөгжүүлнэ.	Инкубатор	Тоо	-	10	21	ХХААХҮЯ	ХНХЯ, Аймаг, сумын Засаг дарга, ИТХ
1.4.4	Залуу малчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулан нэвтрүүлнэ.	Жендэрийн мэдрэмжтэй хөтөлбөр	Тоо	0	1	-	ХХААХҮЯ	БШУЯ
1.4.5	Туслах малчдын амьжиргааг дэмжих, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, мэргэжил эзэмшүүлэх, хүний эрхийн зөрчил, хүйсийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлээс хамгаалах тусгай төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөө, хэрэгжилт	Хувь	0	35	70	ХХААХҮЯ	ХНХЯ, ХЭҮК, Аймаг, сумын ИТХ, Засаг дарга
1.4.6	Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр хөдөөгийн эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ нэвтрүүлнэ.	Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан эмэгтэйчүүд	Тоо	0	1000	3000	БОАЖЯ	ХХААХҮЯ
1.4.7	Улирлын шинжтэй ажил хөдөлмөр, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд ЖДШ хийж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	ЖДШ, төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	0	50	100	ХХААХҮЯ	УУХҮЯ, ХНХЯ, Аймаг, сумын ИТХ, Засаг дарга

1.4.8	Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай НҮБ-ын тогтоолын хэрэгжилтийн үндэсний тайлан гаргаж, зөвлөмжийг хэрэгжүүлнэ.	Тайлан	Тоо	0	2	4	ХХААХҮЯ	ХНХЯ, БШУЯ, ЭМЯ
1.5	Зорилт 1.5. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	Арга хэмжээний төлөв-логөө	100	100	ХЗДХЯ	Бүх яам, Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.5.1	Жендэрт суурилсан хүчирхийллийн үндэсний хоёр дахь судалгаа хийнэ.	Судалгаа хийгдсэн эсэх	Тийм/үгүй	0	-	Тийм	ҮСХ	ХНХЯ
1.5.2	Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаанаас гарах зөвлөмжийн дагуу хуулийн хэрэгжилтийг сайжруулна.	Зөвлөмжийн хэрэгжилт	Хувь	0	50	80	ХЗДХЯ, ХНХЯ	Үүрэг хүлээгч бүх байгууллага
1.5.3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журмуудыг хуулийн үзэл баримтлал, агуулгын үүднээс шинжилж, боловсронгуй болгоно.	Үнэлгээ хийгдсэн, сайжруулсан журам, сургалтын хөтөлбөр батлагдсан эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	ХНХЯ
1.5.4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтын ажиллагааг сайжруулсан Баянхонгор зэрэг аймгийн сайн туршлагыг судалж нэвтрүүлнэ.	Сайн туршлага нэвтрүүлсэн аймаг, сум, дүүрэг	Тоо	0	50	85	ХЗДХЯ	ХНХЯ, ТББ, Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.5.5	Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх цогц үйлчилгээний туршлага, арга зүйг орон нутгийн удирдлага, ТББ-уудад нэвтрүүлж, чадавхжуулна.	Чадавхжсан аймаг	Тоо	3	6	12	ХЗДХЯ, ГХУСАЗЗ	Бүх шатны ИТХ, Засаг дарга, ТББ
1.5.6	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон өрх толгойлсон эмэгтэйчүүдэд зориулсан нийтийн сууцыг сургууль цэцэрлэгт ойрхон барьж байгуулна.	Барьсан нийтийн сууц	Тоо	0	1	5	Нийслэл, аймгийн Засаг дарга, ИТХ	БХБЯ

1.5.7	Малчдыг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлтийг сайжруулах, хохирогчийг хамгаалах үр дүнтэй тогтолцоо, арга зүйг бий болгоно.	Тогтолцоо бүрдсэн, аргачлал батлагдсан эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ, ХЭДХЯ	ХХААХҮЯ, ХЭҮК
1.5.8	Засаг захиргааны анхан шатны нэгжид ажиллаж байгаа Хамтарсан багийн болон Түр хамгаалах байрны үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлнэ.	Бүрэн санхүүжүүлэх хуулийн заалтын хэрэгжилт, орон нутгаар	Хувь	-	70	100	ХЗДХЯ	Сангийн яам, ХНХЯ, ЭМЯ, Бүх шатны ИТХ, Засаг дарга
1.5.9	Хүүхэд, ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хувийн нууцаа хамгаалуулах эрхийг бүрэн баталгаажуулсан эрх зүйн орчин бий болгоно.	Хуулийн зохицуулалт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	ХНХЯ, ХЭҮК
1.5.10	Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн дарамтын хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар хүртээмж, цар хүрээг сайжруулна.	Үйлчилгээ үзүүлэх журам, хэрэгжилт, санхүүжилтийн өсөлт	Тоо, Хувь, Хувь	25 - -	28 50	100 Санхүү-жилт нэмэгд-сэн байна.	ХЗДХЯ	
1.5.11	Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвд шүүхийн шинжилгээний үйлчилгээг нэгтгэн үзүүлнэ.	Шүүхийн шинжилгээний үйлчилгээтэй НЦҮТ	Хувь	0	100	-	ХЗДХЯ	
1.5.12	Нийслэл дэх Түр хамгаалах байрыг хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрөлжүүлэн байгуулж, санхүүжилтийг хуулийн дагуу шийдвэрлэнэ.	Төрөлжсөн хамгаалах байр	Тоо	0	6	10	ХЗДХЯ, ХНХЯ	Сангийн яам, ЭМЯ, Нийслэлийн ИТХ, Засаг дарга

1.5.13	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна.	Тогтмолжсон арга хэмжээ	Тоо	1	5	16	Бүх яам	Мэргэжлийн холбоод, Бүх шатны ИТХ, Засаг дарга
2	ЗОРИЛГО 2. Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж, тэгш оролцоог дэмжинэ.	Жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлт: Эдийн засгийн оролцоо, боломж	Оноо	0.765	0.785	0.795	ХНХЯ	ЖУХ
2.1	Зорилт 2.1. Хөдөлмөрийн зах зээл дэх нас, хүйсийн ялгаварлалыг бууруулна.	Нийт ажиллагчид, насны бүлэг, хүйсээр	Мянган хүн	1127.1	1420	1710	ХНХЯ	Бүх яам
2.1.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, түүний хэрэгжилтэд жендэрийн дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргана.	Жендэрийн дүн шинжилгээ хийгдсэн эсэх, зөвлөмжийн хэрэгжилт	Тийм/үгүй, Хувь	-	Тийм 30	- 70	ХНХЯ	АОМХ
2.1.2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан төрийн албан дахь хөдөлмөрийн харилцааны баталгааны хэрэгжилтэд хяналтын тодорхой хэрэгслийг бий болгож ашиглана.	Хэрэгжилт	Хувь	0	60	100	ТАЗ	ХНХЯ, Бүх шатны Засаг дарга
2.1.3	Төр, ТББ, хувийн хэвшил дэх ажил эрхлэлтэд саад болж байгаа бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг арилгахад чиглэсэн Засгийн газар, Ажил олгогчдын мэргэжлийн холбоод, Үйлдвэрчний эвлэл, хэвлэл мэдээлэл, холбогдох олон улсын түншлэгчидтэй хамтын ажиллагааны платформ үүсгэж ажиллуулна.	Платформд нэгдсэн байгууллага	Тоо	0	10	25	ХНХЯ, АОМХ, ҮЭ	ТАЗ, ХЭҮК, МХЕГ, ҮАГ, ХМБ, ТББ, ОУ-ын хөгжлийн түншлэгчид
2.1.4	Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн үлгэрчилсэн зааврын хэрэгжилтэд хөндлөнгүйн үнэлгээ хийж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	Хөндлөнгүйн хяналт шинжилгээ, үнэлгээ	Тоо	0	1	2	ХНХЯ, ХЭҮК, МХЕГ	ТАЗ, ҮЭ, АОМХ

2.1.5	Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлого, төлөвлөлтийг баталж, хэрэгжүүлнэ.	Бодлого төлөвлөлт, хэрэгжилт	Хувь	Бодлогын төсөл	30	70	ХНХЯ, ҮЭ	ЖҮХ, ҮЭ, АОМХ, Бүх шатны Засаг дарга
2.1.6	Хувийн хэвшилд байгууллагын жендэрийн төлөвлөлт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.	Удирдамжийн дагуу жендэрийн төлөвлөгөө хэрэгжүүлж буй байгууллага, салбараар	Тоо	Удирдамж	32	80	ЖҮХ	ХНХЯ, АОМХ, ҮЭ, МУХАУТ
2.1.7	Хувийн хэвшилд зориулсан жендэрийн сургалтын модуль боловсруулж нэвтрүүлнэ.	Сургалтын модуль боловсруулж, сургалтын тогтолцоонд нэвтрүүлсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ЖҮХ	АОМХ, ҮЭ, МУХАУТ, МХЕГ
2.1.8	Гэрийн хөлсгүй хөдөлмөрийг үнэлэх үнэлгээний арга зүйг нэвтрүүлж, үндэсний тооцооны системд тусгана.	Аргачлал, үзүүлэлт нэвтрүүлсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ, ҮСХ	ЭЗХЯ, Сангийн яам
2.1.9	Хүүхдээ асарч буй эцэг, эхийн нийгмийн даатгалыг төрөөс хариуцдаг тогтолцоонд уе шаттай шилжинэ.	Хуулийн зохицуулалт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ	АОМХ, ҮЭ
2.1.10	Ахмад эмэгтэйчүүдээс үзүүлэх зөвлөх үйлчилгээний төрөл, хамрах хүрээг өргөтгөнө.	Үйлчилгээний төрөл, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ахмад настан, хүйсээр	Хувь	-	15	30	ХНХЯ	АОМХ, ҮЭ
2.1.11	Хүүхэд асрах үйлчилгээний зардлыг ач, зээгээ асарч буй ахмад настанд олгох зэрэг арга хэмжээг судалж шийдвэрлэнэ.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ, БШУЯ	Сангийн яам
2.1.12	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгоно.	Жендэрийн мэдрэмжтэй бодлого, арга хэмжээний хэрэгжилт	Хувь	0	25	50	ХНХЯ	Мэргэжлийн холбоод
2.1.13	Цахим ажлын орчин дахь жендэрийн ялгаварлан гадуурхалтын талаар дүн шинжилгээ хийж, холбогдох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.	Дүн шинжилгээ хийгдсэн эсэх, зөвлөмжийн хэрэгжилт	Тийм/үгүй, Хувь	-	Тийм	Тийм	ЖҮХ	ХЭҮК, ЦХХХЯ, ХНХЯ

2.2	Зорилт 2.2. Зохиистой хөдөлмөр эрхлэлтийг жендэрийн агуулгаар бэхжүүлж, ажил, ар гэр, амьдралын тэнцвэрийг дэмжинэ.	Хөдөлмөр эрхэлж байгаа боловч ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн ам	Хувь	22.2	16.7	11.0	ХНХЯ	Бүх яам
2.2.1	Ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бий болгоно.	Хөшүүрэг, аж ахуйн нэгжийн төрлөөр	Тоо	0	1	3	ХНХЯ, МУХАУТ, ЭЗХЯ	АОМХ, ҮЭ, Сангийн яам, ГЕГ, ТЕГ
2.2.2	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын жендэрийн агуулга, үр нөлөөг сурталчлан дэмжинэ.	Хамрагдсан байгууллага	Хувь	0	30	70	ХНХЯ	АОМХ, ҮЭ, Соёлын яам, МХЕГ
2.2.3	Ажил-ар гэр, амьдралын тэнцвэрийг хангах стратеги гаргаж, төр, хувийн хэвшлийн байгууллагад хэрэгжүүлнэ.	Удирдамж, хэрэгжүүлсэн байгууллага, салбараар Архангай аймгийн Онцгой байдлын газрын сайн туршлагыг дэлгэрүүлэх арга хэмжээ	Хувь	0	50	250	ХНХЯ	ЖҮХ, АОМХ, Бүх шатны ИТХ, Засаг дарга
2.2.4	Сонгосон салбар дахь ажлын байрны орчин нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд жендэрийн үнэлгээ хийж, сайн туршлага гаргаж сурталчилна.	Үнэлгээ, сайн туршлага	Тоо	0	5	10	ХНХЯ	АОМХ, ҮЭ, МХЕГ
2.2.5	Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжих сайн туршлага гаргаж сурталчилна.	Сайн туршлага	Тоо	1	5	10	ХНХЯ	АОМХ, ҮЭ, Соёлын яам
2.2.6	Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн үр чадварыг өрсөлдөж чадахуйц түвшинд байлгах зорилгоор давтан сургалтын тогтолцоог бий болгож, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөөний хэрэгжилт, салбараар	Хувь	0	70	100	ТАЗ, Бүх яам	АОМХ, ҮЭ, Бүх шатны Засаг дарга

2.2.7	Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан, бага насны хүүхэдтэй ажилтанд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах нөхцөл боломж бүрдүүлэх талаар хуулийн хэрэгжилтийг хангах сайн туршлага нэвтрүүлнэ.	Сайн туршлага, нэвтрүүлсэн байгууллага	Тоо	0	16	-	ЖУХ, АОМХ, МУХАУТ	Бүх яам, Бүх шатны Засаг дарга
2.2.8	Төрийн үйлчилгээний байгууллагод харилцааны соёл, сэтгэлзүйн туслалцааг жендэрийн мэдрэмжтэй нэвтрүүлнэ.	Сэтгэл зүйн үйлчилгээтэй байгууллага, салбараар	Тоо	0	16	100	ХНХЯ, ТАЗ	АОМХ, ҮЭ
2.2.9	Ажилтныг байгууллагаас унаагаар хангахад шаардагдах үзүүлэлтийг гаргаж, хамтын гэрээнд тусгана.	Үзүүлэлт, тусгасан хамтын гэрээ	Хувь	0	10	20	ХНХЯ	ҮЭ, МХЕГ, АОМХ
2.2.10	Уул уурхай, дэд бүтцийн зэрэг салбар болон чөлөөт бүсэд гэр бүлээрээ оршин суух орчин, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр эрх зүй, бодлогын орчныг бий болгож, хэрэгжүүлж эхэлнэ.	Бодлого, хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх, хэрэгжилт	Тийм/үгүй, Хувь	Үгүй	Тийм	50	УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ, БХЯ, БХБЯ, ГХЯ, ХЗДХЯ	ХНХЯ, АОМХ, ҮЭ
2.2.11	Гадаадад ажиллах гэрээт ажилчдын гэр бүлийн хамтын амьдралыг дэмжсэн эрх зүйн орчныг бий болгоно.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ	ГХЯ, ҮЭ, АОМХ
2.2.12	Ажлын байрны зураг авалт хийх аргачлалыг жендэрийн мэдрэмжтэй болгоно.	Аргачлал баталж мөрдүүлсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ЖУХ	ХНХЯ, АОМХ, ҮЭ
2.2.13	"Ажиллагчдад жендөр, гэр бүлийн хариуцлагаас үл хамааран тэгш боломж олгох, тэгш хандах тухай" 156, "Цагийн ажлын тухай" 175, "Гэр орны ажлын тухай" 177, "Эхчүүдийн хамгааллын тухай" 183, "Хүчирхийлэл болон дарамтын тухай" 190 дүгээр конвенцуудад нэгдэн орно.	Нэгдэн орсон конвенц	Тоо	0	4	5	ХНХЯ, ГХЯ	ГХЯ, АОМХ, ҮЭ

2.3	Зорилт 2.3. Эдийн засгийн нөөц баялагийн хүртээмж, эрх мэдлийн хуваарилалтад жендэрийн шударга байдлыг хангана.	Хөдөлмөрийн хүрээнд дэх ялгаарлал, дарамтад өртсөн хүн	Тоо	Тодорхойлох шаардлагатай	20 хувь буурсан байна	50 хувь буурсан байна	ХНХЯ	Бүх яам
2.3.1	Үндэсний тооцооны системийн үзүүлэлт, түүний дотор орлогын аргаар тооцсон ДНБ, нөөц ашиглалтын талаарх жендэрийн статистикийн үзүүлэлтийг нэвтрүүлж, дүн шинжилгээнд ашиглана.	Жендэрийн статистик үзүүлэлтийг ашигласан дүн шинжилгээ	Тоо	-	1	2	ХНХЯ	ҮСХ, Сангийн яам, АОМХ, ҮЭ
2.3.2	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүйсээр ангилсан статистик мэдээллийг холбогдох задаргаагаар өргөжүүлж, дүн шинжилгээ хийж, бодлого, хөтөлбөрт ашиглана.	Хөдөлмөрийн статистик ашиглан хийсэн жендэрийн дүн шинжилгээ	Тоо	-	2	5	ҮСХ	Бүх яам, АОМХ
2.3.3	ЖЭТБХТХуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 10.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалтын биелэлтэд хяналт тавих, хариуцлага тооцох механизмыг бүрдүүлнэ.	Хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ТАЗ, ХНХЯ	АОМХ, ҮЭ
2.3.4	Салбар дахь болон салбар хоорондын ажлын үнэлгээ, нийгмийн хувь нэмрийг үнэлэхэд тэгш шударга хандлага тогтоох чиглэлээр үндэсний болон олон улсын түвшний харьцуулсан судалгаа хийнэ.	Судалгаа	Тоо	0	1		ХНХЯ, ТАЗ	ГХЯ, ҮСХ, АОМХ, ҮЭ
2.3.5	Зохиогчийн эрх, бусад оюуны өмчийн эрх эзэмшигчдийн мэдээллийг хүйсээр ангилан гаргана.	Хүйсээр ангилсан мэдээллийн сангийн баяжилт, мэдээллийн төрлөөр	Тоо	0	8	16	ХЗДХЯ	ЦХХХЯ
2.3.6	Иргэний хуулиар зохицуулсан иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх эдийн ба эдийн бус баялагтай холбоотой харилцаанд дахь хүйсээр ангилсан мэдээллийг бүрдүүлнэ.	Мэдээлэл бүрдэлт	Хувь	0	50	100	ХЗДХЯ	Мэргэжлийн холбоод

2.3.7	Бизнес, орлого, хөрөнгө эзэмшил, татвар, санхүү, бүртгэлийн тогтолцоонд жендэрийн шинжилгээ хийж, холбогдох жендэрийн статистик үзүүлэлт нэвтрүүлнэ.	Шинжилгээ, жендэрийн статистик үзүүлэлт нэвтэрсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	ҮСХ, ЭЗХЯ, Сангийн яам
2.3.8	Бизнес эрхлэхүйн үзүүлэлт ба бизнесийн орчинд хийсэн жендэрийн үнэлгээнд үндэслэн шаардлагатай арга хэмжээг төлөвлөж, төр, хувийн хэвшил, бизнесийн холбоод хамтарч хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	0	50	100	ЭЗХЯ	АОМХ, МУХАУТ, ХХААХУЯ, ХНХЯ
2.3.9	Уул уурхай, барилга, хот байгуулалт, зам тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн бүтээн байгуулалтад болон холбогдох бусад салбарт хүний эрх, жендэр, нийгмийн үр нөлөөний үнэлгээ нэвтрүүлж, үр дүнг бодлого төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлнэ.	Үнэлгээ хийгдсэн салбар, бодлого төлөвлөлтийн хэрэгжилт	Тоо, Хувь	-	5 30	70	УУХУЯ, БХБЯ, ЭХЯ, ЗТХЯ	ХНХЯ, ХЭҮК
2.3.10	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай арга хэмжээ, зохицуулалт нэмж тусгана.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ	ҮЭ
2.3.11	Эмэгтэй хэв шинжийн бизнесийг тодорхойлж, дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ	ХЗДХЯ, ХХААХУЯ, АОМХ, ҮЭ
2.3.12	Төрийн болон орон нутгийн өмчийн худалдан авалтад оролцох аж ахуйн нэгжийн шалгуур үзүүлэлтэд Хөдөлмөрийн тухай хуулийн 6, 7 болон 43 дугаар зүйлийн 43.3-т заасан заалтыг хэрэгжүүлсэн тухай шалгуур үзүүлэлт тусгана.	Шалгуур үзүүлэлт боловсруулсан эсэх, хууль, эрхзүйн баримт бичигт тусгасан эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	Сангийн яам	ХНХЯ
2.3.13	"Ижил үнэ цэнтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчим хэрэгжүүлэх аргачлал"-ыг жендэрийн мэдрэмжтэй нэвтрүүлнэ.	Хэрэгжилт	Хувь	0	20	40	ХНХЯ	АОМХ, ҮЭ

2.3.14	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд жендэрийн үр дагаврын үнэлгээ хийнэ.	Үр дагаврын үнэлгээ	Тоо	0	1	-	Нийслэлийн Засаг дарга, ИТХ	ЖУХ
2.3.15	Нийтийн тээврийн үйлчилгээг жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тусгай хэрэгцээт хүмүүсийн зорчиход тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, нийслэлийн нийтийн тээврийн цагийг уртасгах, шөнийн чиглэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	Жендэрийн дүн шинжилгээ хийгдсэн эсэх, үйл ажиллагааны хэрэгжилт	Тийм/ Үгүй, Хувь	Үгүй 0	Тийм 50	Тийм 100	Нийслэлийн Засаг дарга, ИТХ	ЗТХЯ, АОМХ, ҮЭ
2.3.16	Хүн амын шилжилт хөдөлгөөн, түүнээс үүдсэн ажил эрхлэлт, амьжиргааны түвшний ялгаа, гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцны төлөвлөлт, дэд бүтэц, төрийн үйлчилгээний хүртээмжид жендэрийн дүн шинжилгээ хийж, хот төлөвлөлтийн бодлого, стандартыг жендэрийн мэдрэмжтэй болгоно.	Жендэрийн дүн шинжилгээ хийгдэж, бодлого, стандартад холбогдох өөрчлөлт орсон эсэх	Тийм/ үгүй	Үгүй	Тийм	Тийм	БХБЯ	МХЕГ, Нийслэлийн Засаг дарга, ИТХ
2.3.17	Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлнэ.	Сургалтад хамрагдсан ИТХ-ын Төлөөлөгчид	Хувь	0	80	100	Бүх шатны ИТХ	ЖУХ, ТББ
2.3.18	Төр, хувийн хэвшлийн байгууллага ажилтны болон орон нутгийн хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг байгуулахыг дэмжсэн санхүү, татварын хөшүүрэг нэвтрүүлнэ.	Санхүү, татварын хөшүүрэг бий болсон эсэх	Тийм/ үгүй	Үгүй	Тийм	Тий	Сангийн яам	Бүх шатны ИТХ, Засаг дарга
2.4	Зорилт 2.4. Цар тахлын сөрөг нөлөөг даван туулах бодлого, үйл ажиллагааг жендэрийн агуулгаар хэрэгжүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь	Хувь	5.6	8.0	18.0	ХХААХҮЯ	ХНХЯ

2.4.1	COVID-19 цар тахлын болон дараах үеийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдалд нарийвчилсан судалгаа хийж, зөвлөмж гаргана.	Судалгаа хийгдэж, зөвлөмж хүргэгдсэн эсэх	Тийм /үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	ХНХЯ	ХНХЯ
2.4.2	Ковид-19 цар тахлыг даван туулах, түүний нөлөөнөөс богино хугацаанд ангижрахад чиглэсэн тусгайлсан төлөвлөгөөг жендэрийн мэдрэмжтэй гаргаж, хэрэгжүүлнэ.	Тусгай төлөвлөгөө хэрэгжилт	Хувь	0	100	100	100	ЭЗХЯ, ЗГХЭГ	Сангийн яам, Бүх шатны ИТХ, Засаг дарга
2.4.3	Ковид-19 цар тахлын дараах шинэ хэвийн нөхцөлд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, эдийн засгийн чадавхжилтыг дэмжихүйц гадаад худалдааны бодлого боловсруулан, Олон улсын худалдааны байгууллагын гишүүн орнуудын хүрээнд хэрэгжүүлнэ.	Бодлого тодорхойлсон эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	ГХЯ	ЭЗХЯ
2.4.4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн худалдан авалтад эмэгтэй хэв шинжийн ААН-ийн, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн худалдан авалтыг дэмжих тусгай арга хэмжээ авна.	Тусгай арга хэмжээ авах талаар хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Сангийн яам	ЭЗХЯ, Бүх шатны ИТХ, Засаг дарга
2.4.5	Эрсдэлтэй/гамшгийн нөхцөлд тэргүүн шугамд ажиллагчдын ажлын орчин нөхцөлд жендэрийн шинжилгээ хийж, шинэ хэвийн нөхцөлд нийцүүлэх удирдамжийг жендэрийн мэдрэмжтэй гаргаж нэвтрүүлнэ.	Удирдамж нэвтрүүлсэн эсэх Удирдамжийг нэвтрүүлж, сургалтын тогтолцоотой болсон байгууллага	Тийм/үгүй Хувь	Үгүй 0	Тийм	Тийм	Тийм	ХНХЯ ХНХЯ	ЭМЯ, ОБГ ЭМЯ, ОБГ
2.4.6	Цар тахлын үед болон дараа хөдөлмөрийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалт гарахаас сэргийлэх, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангах чиглэлээр зөвлөмж гарган хэрэгжүүлж, тогтолцоо чадавхыг байгууллагын түвшинд бүрдүүлнэ.	Зөвлөмж хүргүүлсэн эсэх Тогтолцоо, чадавх бүрдүүлсэн байгууллага	Тийм/үгүй Хувь	Үгүй 0	Тийм	Тийм	Тийм	ХНХЯ ЖУХ	ЭМЯ ЭМЯ, Бүх яам

2.4.7	Ажиллагчдын цалин хөлсний тогтолцоо, даатгалын тохиолдлыг шинэ хэвийн нөхцөлд нийцүүлэн жендэрийн мэдрэмжтэй шинэчилнэ.	Хууль тогтоомжийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ	Сангийн яам, ТАЗ, АОМХ, ҮЭ
2.4.8	Бичил, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийг өртгийн сүлжээний кластерт нэгтгэж ажлын байр бий болгох төслүүдийг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлнэ	Жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлсэн төслүүдийн хэрэгжилт	Хувь	0	50	100	ХХААХҮЯ	ХНХЯ
2.4.9	Бичил, жижиг үйлдвэрлэлийн онцлог хэрэгцээнд нийцсэн бизнесийн бус мөнгөн тусламж, яаралтай үед хэрэглэх капитал хөрөнгийн, санхүүгийн, мэргэжил арга зүйн зэрэг уян хатан дэмжлэгийг тодорхойлон хэрэгжүүлнэ.	Хууль тогтоомжийн өөрчлөлт хийгдсэн эсэх, Дэмжлэг, арга хэмжээний хэрэгжилт	Тийм/үгүй, Хувь	Үгүй 0	Тийм 30	Тийм 60	ХХААХҮЯ	Сангийн яам, ЭЗХЯ, ОБГ
3.	ЗОРИЛГО 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлнэ.	Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлэх, жендэрийн бодлоготой эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ХЭДХЯ, ЖҮХ	Бүх яам
3.1	Зорилт 3.1. Бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн статистик, жендэрийн дүн шинжилгээний хүртээмж, ашиглалтыг сайжруулна.	Жендэрийн статистик, судалгаа шинжилгээ, бусад мэдлэгийн бүтээгдэхүүний мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ЖҮХ, УСХ	Бүх яам
3.1.1	Хөгжлийн бодлого төлөвлөлийн хууль тогтоомжид жендэрийн мэдээллийн зарчид, жендэрийн шалгуур үзүүлэлтийн ашиглалтыг тусгана.	Хууль тогтоомжийн өөрчлөлт хийгдсэн эсэх	Тийм/үгүй	Үгүй	Тийм	Тийм	ЭЗХЯ	ЖҮХ
